



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/31-11-ШТА-ГА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, үр дүнг 2026 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2026 оны 2 дугаар улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын албаны менежер (Э.Мөнхмандах)-д үүрэг болгосугай.

4.Тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн Аудитын газар, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ

1425010044



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ УДААШРАХ, ХЭРЭГЖИХГҮЙ БОЛОХ, ЧАНАР БАЙДАЛ, АШИГЛАЛТАД СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: НТАГ-2025/31-11-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал

Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn

Нийслэл дэх Төрийн аудитын газрын Ахлах менежер Ч.Болд

Утас: 70007734, Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Аудитын менежер Э.Мөнхмандах

Утас: 327787, Цахим хаяг: munkhmandakhe@audit.gov.mn

Аудитын менежер Л.Саранбаатар

Утас: 327787, Цахим хаяг: saranbaatarl@audit.gov.mn

Ахлах аудитор С.Анужин

Утас: 327787, Цахим хаяг: anujins@audit.gov.mn

Аудитор О.Оргил

Утас: 327787, Цахим хаяг: orgilo@audit.gov.mn

Аудитор Д.Эрдэнэбулган

Утас: 327787, Цахим хаяг: erdenebulgand@audit.gov.mn



АГУУЛГА

Гарчиг	Хуудас
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Хавсралтын жагсаалт	4
Ерөнхий зүйл	5
Ерөнхий мэдээлэл	6
Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.	7-13
1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?	7-10
1.2. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?	10-13
Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх.	14-22
2.1. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?	14-17
2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн, үр нөлөөтэй байна уу?	18-20
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт хэвийн байна уу?	20-22
Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх	23-28
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?	23-25
3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?	25-28
Аудитын дүгнэлт	29
Аудитын зөвлөмж	30
Холбогдох байгууллагын санал	31-33
Саналд өгсөн тайлбар	34
Хавсралт	35-39

**Товчилсон үгийн тайлбар**

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ДОНХС	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЗЗНДТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НД	Налайх дүүрэг
НДАГ	Нийслэлийн Дотоод аудитын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НОНХС	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТГУХ	Төлөвлөлт, гүйцэтгэл удирдлагын хэлтэс
ТНААХ	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
СБД	Сүхбаатар дүүрэг
СС	Сангийн сайд
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УМС	Удирдлага мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

**Хүснэгтийн жагсаалт**

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	ОНХС-ийн эх үүсвэр	7
Хүснэгт 2	Өмнөх оны үлдэгдэл зөрүү	8
Хүснэгт 3	ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг	8
Хүснэгт 4	2024 оны ДОНХС-д олгосон санхүүжилт	9
Хүснэгт 5	Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэр	9
Хүснэгт 6	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд өгсөн иргэдийн оролцоо, санал	10
Хүснэгт 7	Шинээр хэрэгжүүлэх ТАХ	11
Хүснэгт 8	Худалдан авах ажиллагааны явц	14
Хүснэгт 9	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам	15
Хүснэгт 10	Нийслэл, дүүргийн ОНХС-ийн санхүүжилтийн судалгаа	17
Хүснэгт 11	Олгосон санхүүжилт	17
Хүснэгт 12	ТАХ-ний хэрэгжилтийн байдал	18
Хүснэгт 13	ТАХ-ний ангилал	18
Хүснэгт 14	Ашиглалт хангалтгүй ТАХ	20
Хүснэгт 15	Захиалагчийн хяналтын мэдээ	24
Хүснэгт 16	ТАХ-г данс бүртгэлд тусгасан байдал	26
Хүснэгт 17	Удирдлага мэдээллийн системд байршуулсан байдал	27
Хүснэгт 18	Шилэн дансны мэдээлэл	27-28

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх ерөнхий нэршлээр баталсан ТАХ-ний жагсаалт	31
Хавсралт 2	ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх ерөнхий нэршлээр баталсан ТАХ-ний жагсаалт	31-33
Хавсралт 3	НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт	33-34
Хавсралт 4	ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт	34-35



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ОНХС-ийн 2024 оны төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, өмнөх онуудаас дамжин хэрэгжих болон шинээр эхлэх ажлуудын санхүүжилт, гэрээний хэрэгжилтийг түүвэрлэн хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБООУС 100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817:2020, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ ТБОНӨХБАҮХАТХууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ МУ-ын ЗГ-ын 2016 оны 153 тогтоол;
- ✓ 2017 оны 230 дугаар тогтоол;
- ✓ СС-ын 2012 оны “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” ;
- ✓ 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” ;
- ✓ нийслэл, дүүргийн ИТХ, ЗД-ын тогтоол, захирамж, шийдвэр.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.8-д заасны дагуу 2024 оны нийслэл, дүүргийн ОНХС-д 71,045.2 сая төгрөгийн орлого бүрджээ. Үүнд:

- Өмнөх оны үлдэгдэл санхүүжилт 22,868.3 сая төгрөг;
- ОНХС-ийн шилжүүлэг 48,042.6 сая төгрөг;
- Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээс 134.3 сая төгрөг тус тус бүрдсэн байна.

НИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 122 дугаар тогтоолоор НОНХС-ийн орлогын хэмжээг баталж, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 25/32 дугаар тогтоолоор тодотгосон байна.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос хэрэгжсэн 30,862.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 140 ТАХ, шинээр 65,042.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 ТАХ, нийт 95,904.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 415 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.

Үүнээс 323 ТАХ буюу 61.1 хувь нь хэрэгжсэн, 87 ТАХ буюу 16.4 хувийн хэрэгжилт дутуу, 119 ТАХ буюу 22.5 хувь нь хэрэгжээгүй байна.

Тайлант онд 72,959.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 361 ТАХ-нд 44,553.1 сая төгрөг буюу 61.1 хувийг нь олгожээ.

Аудитын түүврийг хийхдээ 2024 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- Төлөвлөлт: 2024 онд шинээр төлөвлөсөн 65,042.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 ТАХ-г бүрэн;
- Худалдан авалт зохион байгуулсан 410 ТАХ-ээс 69,508.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 108 ТАХ буюу 26.3 хувийг;
- Гэрээний хэрэгжилт: 2024 онд бүрэн дууссан, санхүүжилт олгосон 51,239.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 323 ТАХ-ээс 24,594.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 115 ТАХ буюу 35.6 хувийг;
- Санхүүжилт: Шинээр болон он дамжин хэрэгжсэн 361 ТАХ-нд олгосон 44,553.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн хамруулсан.

**БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН ЭСЭХ.**

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн төлөвлөж, хөрөнгийг ОНХС-ийн шилжүүлэг, өмнөх оны үлдэгдэл санхүүжилт, малын тоо толгойн албан татвар зэрэг эх үүсвэрээр бүрдүүлж хуваарилжээ.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээр бүрдүүлсэн ч ОНХС-аас НОНХС-д, НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?

1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2¹, 59.1.3², 59.1.5³-т заасны дагуу бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн орлогыг 2024 онд дараах 3 төрлийн эх үүсвэрээс нийт 71,045.2 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 1. ОНХС-ийн эх үүсвэр

(сая.төг)

№	Нэр	Нийт санхүүжилт	Үүнээс		
			Өмнөх оны үлдэгдэл	ОНХС-ийн шилжүүлэг	Малын тоо толгойн албан татвар
1	Нийслэл	32,389.3	13,186.7	19,202.6	-
2	БЗД	7,701.8	2,468.1	5,233.7	-
3	СХД	7,018.6	1,837.1	5,150.2	-
4	БНД	6,866.6	346.2	6,422.6	97.7
5	ХУД	5,853.6	2,753.0	3,100.6	-
6	НД	3,764.0	133.9	3,630.1	-
7	ЧД	2,704.9	837	1,867.8	-
8	БГД	2,360.7	829.2	1,531.5	-
9	СБД	1,752.7	416.7	1,335.9	31.3
10	БХД	633.1	60.4	567.5	5.3
Нийт		71,045.2	22,868.3	48,042.6	134.3

ОНХС-ийн эх үүсвэрийн 32.2 хувь нь өмнөх оны үлдэгдэл санхүүжилт, 67.6 хувь нь ОНХС-ийн орлогын шилжүүлэг, 0.2 хувь нь малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээс бүрджээ.

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.8⁴-д заасны дагуу тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулжээ.

Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор өмнөх оны үлдэгдлийг 18,501.8 сая төгрөг гэж баталсан ч нийслэл, дүүргийн ОНХС-ийн дансны үлдэгдлийг тулгахад 22,868.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 4,366.5 сая төгрөгөөр дутуу баталсан байна.

¹ 59.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;

² 59.1.3 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

³ 59.1.5 Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

⁴ 8.8.ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.

**Хүснэгт 2. Өмнөх оны үлдэгдэл зөрүү**

(сая.төг)

№	Нэр	ИТХ-ын тогтоолоор /тодотгол/	Дансны үлдэгдлээр	Зөрүү үнийн дүн
1	Нийслэл	9,409.0	13,186.7	3,777.7
2	ХУД	2,566.1	2,753.0	186.9
3	СХД	1,659.4	1,837.1	177.7
4	ЧД	727.6	837.0	109.4
5	БНД	271.6	346.2	74.6
6	НД	111.2	133.9	22.7
7	БХД	42.8	60.4	17.6
8	БЗД	2,468.1	2,468.1	-
9	БГД	829.2	829.2	-
10	СБД	416.7	416.7	-
Нийт		18,501.8	22,868.3	4,366.5

Хүснэгтээс харахад БХД, БНД, НД, СХД, ХУД, ЧД, НИТХ нь 17.6-3,777.7 сая төгрөгөөр дутуу баталсан нь дансны үлдэгдлийн дүнгээ баталгаажуулаагүй, төсвийн төсөл бэлдсэн ажилчдын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээс бүрдүүлсэн ч тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт бүрэн тусгаж, батлуулах шаардлагатай байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээс бүрдүүлжээ.

1.1.2. ОНХНС-аас нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж олгосон уу?

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС-аас НОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 50,167.0 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2⁵, ЗГ-ын 2017 оны "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу СЯ-аас Нийслэлийн ОНХС-д тухайн онд олгох орлогын шилжүүлгийг баталсан аргачлалын дагуу хуваарилсан.

НОНХС-д хуваарилсан хөрөнгийг олгохдоо төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй, дутуу олгосон байна. Тухайлбал:

- 2024 оны 8 дугаар сарын шилжүүлгийн тухайн хугацаанд олгоогүй;
- 4, 5, 6, 7, 9, 10 дугаар сард 8.6-411.7 сая төгрөгөөр дутуу олгосон;
- 11, 12 дугаар сард өмнөх саруудын дутуу олгосон зөрүүг нөхөж олгосон ч нийт дүнгээр 2,124.6 сая төгрөгийн орлогыг дутуу олгосон байна.

Хүснэгт 3. ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг

(сая.төг)

№	Үзүүлэлт, сар	Төлөвлөгөө	Сангийн яамны шилжүүлэг	Зөрүү дүн
1	1 дүгээр сар	-	-	-
2	2 дугаар сар	4,340.3	4,340.3	-
3	3 дугаар сар	4,340.3	4,340.3	-
4	4 дүгээр сар	4,349.8	4,288.3	(61.5)
5	5 дугаар сар	4,340.3	4,296.4	(43.9)
6	6 дугаар сар	4,340.3	4,331.7	(8.6)
7	7 дугаар сар	4,349.8	4,211.2	(138.6)
8	8 дүгээр сар	4,340.3	0.0	(4,340.3)
9	9 дүгээр сар	4,340.3	4,199.8	(140.5)
10	10 дугаар сар	5,145.0	4,733.3	(411.7)
11	11 дүгээр сар	5,135.5	7,965.5	2830.0
12	12 дугаар сар	5,145.0	5,335.5	190.5
Нийт		50,167.0	48,042.6	(2,124.6)

ОНХНС-аас НОНХС-д хуваарилсан хөрөнгийг дутуу олгосон нь орлогын шилжүүлгийн эх үүсвэрийн бүрдүүлэлтээс шалтгаалсан байна.

⁵ 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;



Дүгнэлт: ОНХНС-аас нийслэлийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй, нийт 2,124.6 сая төгрөгийн орлогыг дутуу олгосон.

1.1.3. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон уу?

НЗД-ын 2024 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн А/12 дугаар захирамжаар НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлэг болон хуваарийг баталсан.

Тус хуваарьт НЗД-ын 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А/223, 6 дугаар сарын 20-ны өдрийн А/734, 10 дугаар сарын 07-ны өдрийн А/1184 дугаар захирамжаар 4 удаа өөрчлөлт орсон.

Дээрх өөрчлөлтүүдээр НОНХС-аас ДОНХС-д олгохоор анх баталсан 19,097.4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг нь 11,017.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 30,115.3 сая төгрөг болжээ.

Үүнээс ДОНХС-д 28,840.0 сая төгрөг буюу 95.8 хувийг шилжүүлсэн, 1,275.3 сая төгрөгийг шилжүүлээгүй байна. Энэ нь ОНХНС-аас НОНХС-д хуваарилсан хөрөнгийг дутуу олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 4. 2024 оны ДОНХС-д олгосон санхүүжилт (сая.төг)

№	Дүүргийн нэр	Төлөвлөгөө	Олгосон санхүүжилт	Дутуу шилжүүлсэн дүн
1	БНД	6,706.7	6,422.6	284.0
2	БЗД	5,465.1	5,233.7	231.4
3	СХД	5,377.9	5,150.2	227.7
4	НД	3,790.6	3,630.1	160.5
5	ХУД	3,237.7	3,100.6	137.1
6	ЧД	1,950.4	1,867.8	82.6
7	БГД	1,599.2	1,531.5	67.7
8	СБД	1,395.0	1,335.9	59.1
9	БХД	592.6	567.5	25.1
	Нийт	30,115.3	28,840.0	(1,275.3)

Дүгнэлт: Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн ОНХС-д олгох орлогыг хуваарийн дагуу шилжүүлсэн ч 1,275.3 сая төгрөг дутуу олгосон.

1.1.4. Нийслэл, дүүргийн ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөсөн үү?

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.1⁶, 60.2.4⁷, 60.2.7⁸, 60.2.8⁹, 60.2.9¹⁰-т заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр хуульчилсан.

Нийслэлийн БНД, БХД, НД, СХД-үүд нь малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр нийт 279.3 сая төгрөг орлогыг ДОНХС-д бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 5. Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэр (сая.төг)

№	Дүүрэг	Төлөвлөлт	ТАХ-ний тоо	Гүйцэтгэл
1	БНД	140.5	3	97.7
2	СХД	86.5	5	31.3
3	НД	47.0	-	-
4	БХД	5.3	-	5.3
	Нийт	279.3	8	134.3

⁶ 60.2.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

⁷ 60.2.4.татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

⁸ 60.2.7.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

⁹ 60.2.8.малын тоо толгойн албан татварын орлого.

¹⁰ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж.



Гүйцэтгэлээр БНД 97.7 сая, БХД 5.3 сая, СХД 31.3 сая нийт 134.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

СХД, НД, БНД дүүргүүдэд түгээмэл тархацтай ашигт малтмалаас орлого нэмэгдүүлж болох боломжит эх үүсвэрүүд байгаа ч ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас орох төлбөрийг улсын төсөвт шууд татан төвлөрүүлдгээс шалтгаалж нийслэл, дүүргийн ОНХС-д төлөвлөх боломжгүй байна.

Дүгнэлт: Дүүргүүд нь малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр 279.3 сая төгрөгийн орлого төлөвлөж, 134.3 сая төгрөгийг орлого бүрдүүлжээ.

1.2. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдийн саналд тулгуурлаж, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан ч төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хавсралтын 5.2.1, 5.2.2, 5.2.3-т заасны дагуу иргэдээс санал авч зохион байгуулахаар тусгажээ.

Нийслэл, дүүргийн ЗДТГ нь 2024 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг “/onhs.mof.gov.mn/” цахим программ ашиглан 18-аас дээш насны иргэдээс давхардсан тоогоор 604,788 санал авсан байна. Үүнд: Цахимаар 255,809 санал, бүлгийн ярилцлага 1155, цаасаар 347,824 саналыг тус тус ирүүлжээ.

Иргэдээс ирүүлсэн саналд үндэслэн 286 ТАХ-г эрэмбэлж, үүнээс 2024 онд 65,042.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд өгсөн иргэдийн оролцоо, санал (сая.төг)

№	Нийслэл, дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт санал өгсөн иргэдийн тоо	Нийт санал /ажлаар/	Батлагдсан санал		Цуцлагдсан санал
		Цахим	Бүлгийн ярилцлага	цаасаар			тоо	дүн	
1	Нийслэл	139,658	-	4,620	144,278	62	82	33,819.0	-20
2	БГД	8,240	1,155	9,390	18,785	13	13	1,574.2	0
3	БЗД	42,322	-	-	42,322	19	20	5,465.1	-1
4	БНД	5,494	-	11,163	16,657	21	18	6,894.1	3
5	БХД	2,142	-	312	2,454	29	5	597.9	24
6	НД	4,142	-	7,000	11,142	11	44	4,457.6	-33
7	СБД	22,283	-	27,053	49,336	21	5	1,395.0	16
8	СХД	11,129	-	80,000	91,129	81	59	5,464.4	22
9	ХУД	15,459	-	90,912	106,371	4	4	3,424.7	0
10	ЧД	4,940	-	117,374	122,314	25	25	1,950.4	0
	НИЙТ	255,809	1,155	347,824	604,788	286	275	65,042.5	11

Хүснэгтээс харахад дүүргүүд цахим болон цаасаар харилцан адилгүй санал авсан байна. Тухайлбал: ЧД, ХУД, СХД-т 80,000-117,374 иргэн цаасан санал ирүүлсэн байхад БЗД, СБД-т 22,283-42,322 иргэн цахимаар санал ирүүлсэн байна.



Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө иргэд, олон нийтийн саналд үндэслэсэн байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан уу?

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.1.1¹¹, 6.10¹²-т заасны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г нийслэл, дүүргийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, ЗД-ын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөхөөр заажээ.

2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх ТАХ-г “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй нийцүүлэн төлөвлөжээ.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулжээ.

1.2.3. Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангасан төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

Тайлант онд НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,932.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 ТАХ, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 28,801.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 168 ТАХ нийт 49,733.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 230 ТАХ шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Анх баталсан ТАХ-нд 1-5 удаа төсвийн тодотгол хийж НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 33,819.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 82 ТАХ, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 31,223.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 193 нийт 65,042.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 ТАХ болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Шинээр хэрэгжүүлэх ТАХ

(сая.төг)

№	Нэр	НИТХ-ын тогтоол						ДИТХ-ын тогтоол					
		эхний		тодотгол		зөрүү		эхний		тодотгол		зөрүү	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БГД	6	2,400.0	10	2,400.0	4	-	8	768.8	13	1,574.2	5	805.3
2	БЗД	14	4,000.0	17	4,000.0	3	-	19	5,205.1	20	5,465.1	1	260.0
3	БНД	3	800.0	3	1,127.8	0	327.8	14	6,501.3	18	6,894.1	4	392.9
4	БХД	8	400.0	8	400.0	0	-	3	569.7	5	597.9	2	28.2
5	НД	2	800.0	8	800.0	6	-	31	4,277.7	44	4,457.6	13	180.0
6	СБД	4	1,600.0	4	1,600.0	0	-	4	1,328.6	5	1,395.0	1	66.4
7	СХД	10	4,000.0	10	4,230.0	0	230.0	60	5,208.6	59	5,464.4	-1	255.8
8	ХУД	6	1,200.0	11	1,600.0	5	400.0	4	3,083.9	4	3,424.7	0	340.7
9	ЧД	4	1,600.0	4	1,600.0	0	-	25	1,857.6	25	1,950.4	0	92.8
10	Он дамжин	4	3,139.6	6	3,364.6	2	225.0	-	-	-	-	-	-
11	Бусад	1	992.5	1	12,696.6	0	11,704.1	-	-	-	-	-	-
	Нийт	62	20,932.1	82	33,819.0	20	12,886.9	168	28,801.3	193	31,223.5	25	2,422.1

Нийслэл, дүүргийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан 275 ТАХ-нээс 104 ТАХ нь батлагдсан зураг төсөвгүй, нэр байршил нь тодорхой бус 117 ТАХ-г тусган баталжээ.

¹¹ 4.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

¹² 6.10.Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулж ИТХ-д танилцуулж батлуулна.



НОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 82 ТАХ-ний нэр, байршил, төсөвт өртгийг өөрчилж 151 ТАХ болгож НЗД-ын захирамжаар задалсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4-т “санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран төсөл арга хэмжээ нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасныг зөрчжээ. Тухайлбал:

НОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 22,986.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28, ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 12,816.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 89, нийт 117 ТАХ-ний нэр, байршил нь тодорхой бус байхад ерөнхий нэршлээр төлөвлөсөн байна. Хавсралт 1, 2.

НОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 8,713.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31, ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 9,011.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73, нийт 104 ТАХ- зураг төсөвгүй баталсан байна. Хавсралт 3, 4 Тухайлбал:

НОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ.

- “58 дугаар байрны 3-р орцны дээвэр засварын ажил (БГД 19 дүгээр хороо)” 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Амьдрах орчин сайжруулах (БЗД, 2 дугаар хороо) (БЗД)” 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)” 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил (СБД)” 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Нийслэлийн ерөнхий боловсролын 34, 41 дүгээр сургуулийн засварын ажил (ХУД)” 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил (ЧД)” 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.
- “Жишиг амралт, чөлөөт цаг өнгөрөөх тоглоомын талбай байгуулах (НД 1 дүгээр хороо)” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.

ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ.

- “Тоглоомын талбайн тоног төхөөрөмж” 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Гудамж сайжруулах /13-р хороо/” 47.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)” 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Багахангай дүүргийн нэгдүгээр хорооны 2, 3, 4, 5, 6 дугаар байр, хоёрдугаар хорооны 5, 6, 7, 9, 12, 13, 14 дугаар байрны орон сууцуудын фасадын өнгө сэргээх засварын ажил” 549.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Сурын талбайн тохижилт” 19.2.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил (3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 13, 14, 16, 19, 23, 24 дүгээр хороо)” 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “20-р хороо, Цуурайтын аманд тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгах хайрга, дайрган хучилт хийх” 245.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.

Нийслэл, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний нэр, байршил нь тодорхой бус байхад ерөнхий нэршлээр болон зураг төсөвгүй ТАХ-г төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹³, 29.4¹⁴, СС-ын 2021 оны 86 дугаар журмын 3.1.3¹⁵ -д заалттай нийцээгүй байна. Эдгээр нь тухайн ТАХ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй болох, удаашрах, төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд нөлөөлөх эрсдэлтэй байна.

¹³ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

¹⁴ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁵ 3.1.3.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;



Дүгнэлт: Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний 37.8 хувь нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

1.2.4. Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг тусгасан уу?

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2¹⁶-т аймаг, нийслэлийн түвшинд, 4.4¹⁷, 4.5¹⁸-т сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тус тус заасан.

НОНХС-аас шинээр хэрэгжүүлэх 33,819.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 82 ТАХ, ДОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан 31,223.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 193 ТАХ, нийт 65,042.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 ТАХ нь тухайн шатны чиг үүрэгт хамаарах ТАХ байна.

Дүгнэлт: Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ нь орон нутгийн чиг үүрэгт хамаарч байна.

¹⁶ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

¹⁷ Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

¹⁸ Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.



БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ

2.1. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?

НЗД-ын 98 удаагийн захирамжаар НОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 50,217.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 240 ТАХ-ний ХАА зохион байгуулах эрхийг харьяа 19 газарт шилжүүлжээ. /Тайлбар:НЗД-аас 143 ТАХ-г хэрэгжүүлэх захирамж гаргахдаа нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 240 ТАХ болгон хуваасан./

Дүүргийн ОНХС-ийн 45,687.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 289 ТАХ-ний ХАА-г буюу тухайн дүүргийн ХАА-ны албанд зохион байгуулжээ.

Нийслэл, дүүргийн ОНХС-аас тухайн жилд 72,959.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 529 ТАХ-г санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 44,553.1 сая төгрөгийг 361 ТАХ буюу 61.1 хувьд нь санхүүжилтийг олгожээ.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв батлах тухай тогтоолуудаар 2024 онд 95,904.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 415 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

НЗД болон ДЗД нар худалдан авах ажиллагааг зохион байгуулах захирамж гаргахдаа дээрх 415 ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 529 ТАХ болгон хуваажээ.

Үүнээс 2024 онд 95,904.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 529 ТАХ-ний ХАА-г зохион байгуулан 71,570.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 410 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 69,508.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8. Худалдан авах ажиллагааны явц

(сая.төг)

№	Дүүргийн нэр	ХАА зохион байгуулсан		Гэрээ байгуулсан			ХАА үргэлжилж байгаа		Ажлын тоо хэмжээ ирүүлээгүй	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Нийслэл	240	50,217.3	172	31,132.3	31,260.0	60	6,554.1	8	12,530.9
2	БГД	23	2,618.7	23	2,618.7	2,528.5	-	-	-	-
3	БЗД	49	9,941.3	46	9,426.2	9,117.5	1	117.1	2	398.0
4	БНД	22	7,520.3	17	6,772.7	6,629.0	5	747.6	-	-
5	БХД	6	640.6	5	625.0	855.5	1	15.6	-	-
6	НД	48	4,568.8	46	4,498.8	4,401.3	2	70.0	-	-
7	СБД	9	1,811.7	7	1,690.8	1,651.1	2	120.9	-	-
8	СХД	81	8,691.0	69	7,729.4	6,428.7	9	903.2	3	58.5
9	ХУД	13	7,215.3	10	6,190.6	5,714.6	3	1,024.7	-	-
10	ЧД	38	2,679.6	15	885.7	921.8	-	-	23	1,793.9
	Нийт	529	95,904.8	410	71,570.2	69,508.0	83	9,553.3	36	14,781.3

Дээрх ТАХ-ээс 9,553.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 ТАХ-ний худалдан авах ажиллагаа нь 2024 онд бүрэн дуусаагүй, 14,871.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ТАХ нь ажлын даалгавар, тоо хэмжээ ирүүлээгүй зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

**Хүснэгт 9. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам**

(сая.төг)

№	Нийслэл, дүүргийн нэр	Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Гэрээ шууд байгуулах арга		Ерөнхий гэрээ	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	Нийслэл	172	31,260.0	89	24,901.8	52	3,386.6	20	2,592.6	11	379.0
2	БГД	23	2,528.5	5	1,521.5	9	839.9	9	167.1	-	-
3	БЗД	46	9,117.5	41	8,504.7	4	513.2	1	99.5	-	-
4	БНД	17	6,629.0	14	6,588.1	-	-	3	40.9	-	-
5	БХД	5	855.5	2	823.4	-	-	2	20.3	1	11.9
6	НД	46	4,401.3	5	3,091.3	17	954.3	24	355.8	-	-
7	СБД	7	1,651.1	5	1,555.4	2	95.7	-	-	-	-
8	СХД	69	6,428.7	4	2,746.3	43	3,101.9	22	580.5	-	-
9	ХУД	10	5,714.6	10	5,714.6	-	-	-	-	-	-
10	ЧД	15	921.8	2	247.0	8	535.8	5	139.0	-	-
Нийт		410	69,508.0	177	55,694.1	135	9,427.3	86	3,995.7	12	390.9

ХАА зохион байгуулсан ТАХ-ний худалдан авалтын 43.2 хувь буюу 177 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалт, 32.9 хувь буюу 135 ТАХ-г харьцуулалт, 21.0 хувь 86 ТАХ-г гэрээ шууд байгуулах, 2.9 хувь 12 ТАХ-г ерөнхий гэрээгээр худалдан авах аргаар тус тус зохион байгуулжээ.

ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 28,204.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 108 ТАХ буюу 26.3 хувийг аудитын түүвэрт хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

БГД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Стадиум бюлдинг” ХХК-ий шалгарсан 99.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй өнгөлгөөний фасадын ажил. Инженер техникийн ажилтны ажлын туршлагыг баталгаажуулах шаардагдсан жилийн НДШ төлсөн лавлагааг ирүүлээгүй;

БЗД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Шүрэн гоёл” ХХК-ий шалгарсан 370.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажил, ТББ-т заасан 2022, 2023 он тус бүр 194.5 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шалгуурыг хангаагүй, ИТА-ны НДШ төлөлтийн лавлагааг Монгол хэл дээр ирүүлээгүй;
- “Шинэ хотын цамхаг” ХХК-ий шалгарсан 423.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй авто зам засварын ажил. Санал болгож буй ИТА-ын туршлагыг нотлох шаардсан хугацааны НДШ төлөлтийн тодорхойлолтыг ирүүлээгүй;
- “Их баян буурал” ХХК-ий шалгарсан 167.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй явган замын ажил. ХАБЭА-н ажилтан нь үндсэн ажилтан байх шаардлагыг хангаагүй, туслах ажилчдын хөлсөөр ажиллах гэрээг тухайн ТАХ-нд зориулан байгуулаагүй;
- “Антек” ХХК-ий шалгарсан 143.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажил. ТББ-т заасан 2022, 2023 онуудад тус бүр 101.2 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилга угсралт, тохижилтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх шаардлагыг хангаагүй;
- “Си И Си Жи” ХХК-ий шалгарсан 153.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй дугуйн болон явган замын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь 107.2 сая төгрөгөөс багагүй байх шаардлагыг хангаагүй;

НД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Стар энерги сервис” ХХК-ий шалгарсан 85.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй Цахилгаан хангамжийг сайжруулах тоног төхөөрөмж худалдан авах ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь 42.7 сая төгрөгөөс дээш байх шалгуурт банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй, СИП утасны сертификат болон бусад шаардлагатай баримтыг монгол хэл дээр ирүүлээгүй;
- “Босго толгой” ХХК-ий шалгарсан 102.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь 52.1 сая төгрөгөөс дээш байх шалгуурт банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй.



СБД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Силк трасс” ХХК-ий шалгарсан 215.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20-р хороо, Цээнэ 2-р гудамжнаас Даваатын ам хүртэлх тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгах хайрга, дайрган хучилт хийх ажил. ТББ-т заасан 2022, 2023 онуудын жил тус бүрийн борлуулалтын орлого нь 215.9 сая төгрөгөөс багагүй байх шаардлагыг хангаагүй, ажил гүйцэтгэхэд шаардлагатай машин механизмын түрээсийн гэрээг ирүүлээгүй;
- “Аяа” ХХК-ий шалгарсан 636.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй Дрейм дэлгүүрээс хорооны байр хүртэл явган хүний замын ажил. ТББ-т заасан 2022, 2023 он тус бүр 661.0 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй авто зогсоолын ажил гүйцэтгэсэн байх шалгуурыг хангаагүй.

ХУД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Эрчим өгий” ХХК-ий шалгарсан 1,682.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил. ТББ-т заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичгүүдийг ирүүлээгүй;
- “Зоос импекс” ХХК-ий шалгарсан 544.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт бүтээн байгуулалтын ажил багц-2. ТББ-т заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичгүүдийг ирүүлээгүй;
- “Инносолюшн” ХХК-ий шалгарсан 489.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй камержуулалтын ажил. Шаардлагатай зарим баримт бичгүүдийг монгол хэл дээр ирүүлээгүй;
- “РЗА” ХХК-ий шалгарсан 850.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил. ТББ-т заасан 2020, 2021, 2022 онуудад ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шалгуурыг хангаагүй, хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл ирүүлээгүй.

ЧД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Эйч эс эйч арт лимит” ХХК-ий шалгарсан 41.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил. ТББ-т заасан ажил гүйцэтгэх ИТА-ын НДШ-ийг 2024 оны 02, 03, 04 дүгээр саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн байх шаардлагыг хангаагүй;
- “Өндөр буянт хайрхан” ХХК-ий шалгарсан 80.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй хүүхдийн тоглоомын талбайг байгуулах, засварлах ажил. ТББ-т заасан 2022, 2023 онуудын аль нэг жилд 60.7 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тохижилтын ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг тус тус хангаагүй зөрчил илэрсэн.

ХАА-г ил тод нээлттэй, өрсөлдөх тэгш боломжийг ханган зохион байгуулсан ч зарим ТАХ-ний сонгон шалгаруулалтад ТББ болон тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэх, ТАХ-г хэрэгжүүлэх явц, үр дүнд тавих хяналт, шат шатны хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан ч аудитын түүвэрт хамрагдсан ТАХ-ний 14.8 хувьд нь шаардлага хангаагүй гүйцэтгэгчтэй холбоотой зөрчлүүд илэрч байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан уу?



Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд шинэ болон шилжих 529 ТАХ-нд 72,959.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 361 ТАХ-нд 44,553.1 сая төгрөг буюу 61.1 хувийн санхүүжилт олгосон.

Үүнээс өмнөх оноос дамжин санхүүжих 179 ТАХ-нд 18,526.8 сая төгрөг олгохоос 11,480.0 сая төгрөг буюу 62.0 хувь, шинээр хэрэгжих 350 ТАХ-нд 54,432.8 сая төгрөг олгохоос 33,073.1 сая төгрөг буюу 60.8 хувийн санхүүжилтийг тус тус олгожээ.

Хүснэгт 10. Нийслэл, дүүргийн ОНХС-ийн санхүүжилтийн судалгаа (сая.төг)

№	Нэр	Өмнөх оноос хэрэгжсэн				2024 онд шинээр хэрэгжсэн				Нийт			
		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийслэл	97	9,409.0	69	5,082.4	143	23,829.4	66	10,688.4	240	33,238.4	135	15,770.8
2	БГД	10	854.2	7	566.8	13	1,574.2	13	1,429.8	23	2,428.4	20	1,996.6
3	БЗД	29	2,468.1	21	1,880.0	20	5,465.1	15	3,913.1	49	7,933.2	36	5,793.1
4	БНД	4	271.6	3	227.1	18	6,894.1	13	5,896.4	22	7,165.8	16	6,123.5
5	БХД	1	42.8	1	42.8	5	597.9	4	556.4	6	640.6	5	599.2
6	НД	4	111.2	3	64.5	44	3,837.6	36	3,376.3	48	3,948.8	39	3,440.9
7	СБД	4	416.7	3	353.0	5	1,395.0	4	1,279.1	9	1,811.7	7	1,632.1
8	СХД	9	1,659.4	8	1,470.9	72	5,464.4	60	3,378.9	81	7,123.8	68	4,849.9
9	ХУД	8	2,566.1	4	1,187.2	5	3,424.7	3	2,257.9	13	5,990.7	7	3,445.1
10	ЧД	13	727.6	10	605.3	25	1,950.4	18	296.6	38	2,678.1	28	902.0
Нийт		179	18,526.8	129	11,480.0	350	54,432.85	232	33,073.1	529	72,959.6	361	44,553.1

Хэрэгжиж дууссан ТАХ-ний 2,200.7 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн 24 гүйцэтгэгчээс хугацаа хэтрүүлсэн алдангид 36.0 сая төгрөгийг суутган тооцсон байна.

Хүснэгт 11. Олгосон санхүүжилт (сая.төг)

№	Нэр	Батлагдсан санхүүжих дүн		Олгогдсон санхүүжилт		Барьцаанд		Алданги	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийслэл	240	33,238.4	135	15,770.8	80	749.2	7	8.8
2	БГД	23	2,428.4	20	1,996.6	17	100.0	-	-
3	БЗД	49	7,933.2	36	5,793.1	31	369.1	2	2.3
4	БНД	22	7,165.8	16	6,123.5	13	317.3	-	-
5	БХД	6	640.6	5	599.2	2	27.9	-	-
6	НД	48	3,948.8	39	3,440.9	31	97.1	2	9.6
7	СБД	9	1,811.7	7	1,632.1	6	70.3	-	-
8	СХД	81	7,123.8	68	4,849.9	47	300.1	12	7.2
9	ХУД	13	5,990.7	7	3,445.1	5	130.6	-	-
10	ЧД	38	2,678.1	28	902.0	10	39.1	1	8.1
Нийт		529	72,959.6	361	44,553.1	242	2,200.7	24	36.0

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан эсэхийг шалгахад зөрчил илрээгүй ч цаашид анхаарах дараах асуудлууд байна. Тухайлбал:

- Нийслэлийн ЗДТГ нь тайлант онд олгох санхүүжилтийн 47.4 хувь, ЧД-ийн ЗДТГ 33.6 хувийг олгосон нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй ТАХ-г төлөвлөсөнтэй холбоотойгоор ТАХ-ний хэрэгжилт удааширч байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.



2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн, үр нөлөөтэй байна уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтод хүрэх түвшин, гарах үр нөлөөг тодорхойлоогүй байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр ашиг, үр дүнд хүрсэн үү?

Тайлант онд нийслэл, дүүргийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар нийт 529 ТАХ хэрэгжиж дуусахаас 61.1 хувь буюу 323 ТАХ бүрэн хэрэгжсэн, 16.5 хувь буюу 87 ТАХ хэрэгжилт дутуу, 119 ТАХ буюу 22.4 хувь нь хэрэгжээгүй байна.

Хүснэгт 12. ТАХ-ний хэрэгжилтийн байдал

№	Нэр	ТАХ-ний тоо	Гэрээ байгуулсан ТАХ-ээс		Огт хэрэгжээгүй
			Бүрэн хэрэгжсэн	Дутуу хэрэгжсэн	
1	Нийслэл	240	123	49	68
2	БГД	23	18	5	-
3	БЗД	49	32	14	3
4	БНД	22	15	2	5
5	БХД	6	5	-	1
6	НД	48	37	9	2
7	СХД	9	7	-	2
8	СБД	81	67	2	12
9	ХУД	13	5	5	3
10	ЧД	38	14	1	23
Нийт		529	323	87	119

Хэрэгжиж дууссан ТАХ-г ангилбал авто зам, дэд бүтэц 13.3 хувь, тоног төхөөрөмж 30.3 хувь, их засвар 11.1 хувь, тохижилт 35.3 хувь, зураг төсөв 8.4 хувь, малын тэжээлийн нөөц бүрдүүлэх 1.6 хувь байна.

Хүснэгт 13. ТАХ-ний ангилал

№	Нэр	Бүрэн хэрэгжсэн ТАХ-ны тоо	Авто зам, дэд бүтэц	Тоног төхөөрөмж	Их засвар	Тохижилт	Зураг төсөв	Бусад
1	Нийслэл	123	13	66	13	31		
2	БГД	18	4	2	5	7		
3	БЗД	32	5		5	22		
4	БНД	15	3	3	5	1	1	2
5	БХД	5		1	2	2		
6	НД	37	3	8	5	11	9	1
7	СБД	7			-	7		
8	СХД	67	13	9	-	26	17	2
9	ХУД	5	1		1	3		
10	ЧД	14	1	9	-	4		
Нийт дүн		323	43	98	36	114	27	5

Дээрх хэрэгжиж дууссан ТАХ-аас төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн, орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажил болсон зарим сайн жишээнээс дурдвал:

- БГД-т сургууль, цэцэрлэгийн гадна талд тусгаарлах хашаа хайс суурилуулах ажлыг шинээр хийснээр хөдөлгөөний аюулгүй байдал, хүүхдүүд зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд ач холбогдолтой байна.
- БЗД-ийн 25-р хороонд хийгдсэн спорт талбай, тохижилтын ажил нь иргэдийн ая тухтай орчинд амрах, нийтийн биеийн тамираар хичээллэж эрүүл мэнддээ анхаарах сайн талтай байна.
- ХУД-ийн 15,20,24-р хороонд хийгдсэн 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажил нь хүүхэд залуусыг спортоор хичээллэж чөлөөт цагаа зөв боловсон өнөөрүүлэх сайн талтай байна.



- ХУД-ийн Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил (3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 13, 14, 16, 19, 23, 24 дүгээр хороодод хийгдсэнээрээ иргэдийн аюулгүй зорчих ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн.
- НД-ийн Цайз чиглэлийн авто замаас Спорт цогцолбор хүртэлх авто замын ажил нь орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ард иргэдийг спортоор хичээллэх, хүүхэд залуусыг авьяас чадвараа нээн хөгжүүлж спортод дуртай болохыг дэмжсэн ажил болсон байна.

Дүүргийн ЗДТГ-аас нийслэлийн ЗДТГ-т, нийслэлийн ЗДТГ-аас СЯ-нд хүргүүлсэн ОНХС-ийн тайлан мэдээтэй танилцахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт болон хэрэгжилтийн байдалд нийслэл, дүүргийн хэмжээнд үр дүнг бодитой тодорхойлж тайлагнаагүй байна.

Мөн аудитын явцад ТАХ-ний хэрэгжилтийг үзэхэд 61.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд бүрэн хүрээгүй буюу үр ашиг, үр дүн хангалтгүй байна.

Тайлант онд хэрэгжиж дуусах ТАХ-ээс 38.9 хувь нь “ХАА үргэлжилж байгаа мөн зохион байгуулагдаагүй, ажлын даалгаваргүй, тодотголоор хасагдсан” зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд бүрэн хүрээгүй, үр ашиг, үр дүн хангалтгүй байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй байна уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг хангасан, тохижилт, ногоон байгууламж нэмэгдүүлсэн, дэд бүтцийг сайжруулсан ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлсэн ч зарим ТАХ-ний гүйцэтгэл дутуу, ашиглалтын явцад эвдэрсэн, чанар байдал муудсан зэрэг нь ТАХ-ний үр дүн, үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал:

НОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд:

- НХОГ-аас хяналт хэрэгжүүлсэн БЗД-ийн 25-р хороонд хийгдсэн 399.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Спорт талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгч “Люкс даймонд” ХХК. Талбайн ногоон байгууламж зүлэгжүүлэлт хийгээгүй, явган замын бродур эвдэрсэн.

ДОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд:

- СБД-ийн 20-р хороонд хийгдсэн 636.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Дрийм дэлегүүрээс байр хүртэл явган зам”-ын ажил. Явган зам нь зарим хэсэгт хагарч эвдэрсэн.
- СБД-ийн 20-р хороонд хийгдсэн 258.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Сэлбэ 1-р гудамжнаас Түмэн шувуут хүртэлх тоосжилтыг бууруулж шавар шалбааг арилгах, хайрга дайрган хучилт хийх” ажил. 2 байршилд эвдрэл үүссэн ч эвдрэлийг засаагүй.
- СХД-ийн 8-р хороонд хийгдсэн 99.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Явган хүний зам шинээр барих” ажил. Тус замын зарим хэсгүүдэд ашиглалтын явцаас шалтгаалж эвдрэл гэмтэл үүссэн.
- БЗД-ийн 1-р хороонд хийгдсэн 151.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Авто зам засварын ажил”. ОСНААУГ-аас тус замыг сэтэлж дулааны шугам татахдаа замын зарим хэсэгт эвдрэл үүсгэж засаагүй орхисон.
- ХУД-ийн 19-р хороонд хийгдсэн 275.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Явган зам тавих тохижилт хийх” ажил. Авто замд усны хаялга хийхээр явган замын бетоныг хуулсан ч засалгүй орхисон. Явган замын хөтөч хавтан эвдэрсэн чигжээс хийгээгүй.



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд тохижилт, ногоон байгууламж нэмэгдэх, дэд бүтэц сайжрах зэргээр иргэд аюулгүй, таатай орчинд амьдрахад тодорхой үр нөлөө үзүүлж байгаа ч дээрх байдлаар ашиглалтын явцад эвдэлсэн, чанар байдлыг муутгасан зэрэг хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулахаар байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд тохижилт, ногоон байгууламж нэмэгдэх, дэд бүтэц сайжрах зэргээр иргэд аюулгүй, таатай орчинд амьдрахад тодорхой үр нөлөө үзүүлж байна.

2.3.ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна уу?

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс зарим хөрөнгө эвдэрч гэмтсэн байна.

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹⁹ дагуу төсвийн хөрөнгө оруулалт нь төрийн болон орон нутгийн өмч байна.

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 51,239.1 сая төгрөгийн 323 ТАХ бүрэн хэрэгжсэнээс аудитын түүвэрт 24,594.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 115 ТАХ-г хамруулахад зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна. Тайлангийн 2.3.2 дахь хэсэгт дурдсан 20 ТАХ-нд хөрөнгийг эзэнжүүлээгүй, хадгалалт хамгаалалт хангалтгүйгээс шалтгаалж эвдрэл гэмтэл үүсч бүрэн ашиглах боломжгүй байна.

Хүснэгт 14. Ашиглалт хангалтгүй ТАХ

№	Дүүрэг	ТАХ-ний нэр	Гэрээний дүн
1	БЗД	Тохижилт, ногоон байгууламжийн ажил.	294.2
2	БЗД	Амьдрах орчин сайжруулах тохижилтын ажил (4-р хороо)	149.5
3	БЗД	Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт тохижилтын ажил	513.0
4	БЗД	Тохижилт бүтээн байгуулалтын ажил (25-р хороо)	147.5
5	БЗД	Тохижилтын ажил (38-р хороо)	142.9
6	БЗД	Тохижилтын ажил (32-р хороо)	138.1
7	БЗД	Гадна фасад засварын ажил (40-р хороо)	388.1
8	БГД	Тоглоомын талбайн тохижилтын ажил (16, 33-р хороо)	243.0
9	НД	Тоглоомын талбайд тоглоом худалдан авах ажил (1-хороо)	49.5
10	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх ажил	98.3
11	ХУД	Явган зам тавих, тохижилтын ажил (19-р хороо)	275.4
12	ХУД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил	225.1
13	ХУД	3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, орчны тохижилтын ажил 15, 20, 24-р хороо	238.3
14	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил (6-р хороо).	74.6
15	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил (2-р хороо).	41.7
16	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил (1-р хороо).	46.6
17	ЧД	Хорооны нутаг дэвсгэрт камержуулалд хийх (8-р хороо)	134.2
18	ЧД	Хорооны нутаг дэвсгэрт камержуулалд хийх 13-р хороо	127.4
19	ЧД	Гудамж сайжруулах ажил (17-р хороо)	81.5
20	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах засварлах ажил (12-р хороо)	80.5
Нийт			3,489.4

БЗД-ийн 38-р хороонд хийгдсэн 299.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Шаардлагатай тоног төхөөрөмж техник хэрэгсэл, худалдан авч суурилуулах” ажлын хүлээлгэн өгсөн тоног

¹⁹ 6.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.



төхөөрөмжөөс хүлээлгийн сандал 1 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг ашиглалтгүй байгаа нь үр ашиг, үр дүнгүй хөрөнгө оруулалт хийснийг харуулж байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ний ажлын хяналт, хамгаалалт дутуугаас зарим ажлын хэрэгжилт хангалтгүй, зориулалтын дагуу ашиглаагүй байна.

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна уу?

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан байдаг.

ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан 115 ТАХ-г аудитын түүвэрт хамруулан шалгахад 20 ТАХ-нд хөрөнгийг эзэнжүүлээгүй, хадгалалт хамгаалалт хангалтгүйгээс шалтгаалж эвдрэл гэмтэл үүсэж ашиглах боломжгүй болсон дараах зөрчил илэрч байна. Тухайлбал:

- БЗД-т хийгдсэн 294.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт, ногоон байгууламжийн ажил. Сагсны талбайн хавтан эвдэрсэн, тоглоомын талбайн будааг хуурсан, тоглоомын талбайн резин шал хуурсан, олсоор хийсэн хашлага эвдэрсэн.
- БЗД-ийн 4-р хороонд хийгдсэн 149.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй амьдрах орчин сайжруулах тохижилтын ажил. Хүүхдийн гулсууртай тоглоом болон зарим хэсэгт гэрэлтүүлгийн шон эвдэрсэн.
- БЗД-т хийгдсэн 513.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт тохижилтын ажил. Баруун дэнжийн буудлын явган замын хавтан эвдэрсэн, ашиглалтын явцад суулт өгч явган хүн явахад хүндрэлтэй болсон. Мөн Далангийн буудлын явган замын хавтан эвдэрсэн, ашиглалтын явцад суулт өгч явган хүн явахад хүндрэлтэй болсон, автобусны буудлын шилэн хана хагарч лед гэрлүүд алга болсон.
- БЗД-ийн 25-р хороо. 147.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт бүтээн байгуулалтын ажил. Ногоон байгууламжийн тусгаарлах олс тасарч шон эвдэрсэн, түшиц хана хагарч цуурсан.
- Баянзүрх дүүргийн 38-р хороо. 142.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тохижилтын ажил”. Хашааны гагнаас салсан, сандал эвдэрсэн, сагсны талбайн леги хавтангийн ирмэг төмөр эвдэрсэн.
- Баянзүрх дүүргийн 32-р хороо. 138.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тохижилтын ажил”. Бродур 3 газарт бутарч эвдэрсэн.
- Баянзүрх дүүргийн 40-р хороо. 388.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гадна фасад засварын ажил” 19-р байрны 1,2,3-р орц, 70-р байрны 1,2-р орцны хана хагарч фасад хуурсан. үүдний фасад хагарч хуурсан.
- БГД-ийн 16, 33-р хороо. 243.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тоглоомын талбайн тохижилтын ажил”. 16-р хорооны байршилд сандлын тавцан эвдэрсэн. 33-р хорооны байршилд 1 ширхэг хогийн сав алга болсон, 1 сандал эвдэрсэн.
- Налайх дүүргийн 1-р хороо. 49.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тоглоомын талбайд тоглоом худалдан авах ажил”. Тоглоомын талбайн резин эвдэрч, алга болсон, бетон хашлага эвдэрсэн, хашааны гагнаас салсан, хогийн савны таг эвдэрсэн.
- Сонгинохайрхан дүүргийн 42-р хороонд хийгдсэн 98.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх ажил”. Саравчны дээвэр хар цаас хуурсан, 1 ширхэг сандал эвдэрсэн, резин хавтан эвдэрч алга болсон, хашаа эвдэрсэн, гулсууртай тоглоомын самбар алга болсон.



- Хан-уул дүүргийн 19-р хороонд хийгдсэн 275.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Явган зам тавих, тохижилтын ажил” Хүүхдийн тоглоомын талбайн зарим тоглоом эвдэрсэн.
- Хан-уул дүүрэгт хийгдсэн 225.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил”. Шатны хавтан 3 байршилд хагарч эвдэрсэн, гэр хорооллын дундах нарийн гудамжнуудад хийсэн явган замын хаяавч бетон хагарч эвдэрсэн, явган замын цэвэрлэгээ ашиглалт хангалтгүй.
- Хан-уул дүүргийн 15,20,24-р хороонд хийгдсэн 238.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй “3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, орчны тохижилтын ажил”. Хашааны гагнаас салсан, сагсны шийдийн тулгуур эвдэрсэн, сагсны талбайн легио хавтан эвдэрч доорх траншейн тагны бетон хагарч цөмөрсөн.
- Чингэлтэй дүүргийн 6-р хороонд хийгдсэн 74.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил”. Чийрэгжүүлэх 1 ширхэг тоглоом эвдэрсэн, савлуур 2 ширхэг алга болсон.
- Чингэлтэй дүүргийн 2-р хороонд хийгдсэн 41.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил”. 3x3 сагсан бөмбөгийн талбайн легио хавтан болон сандал нь эвдэрсэн, хүүхдийн гулсуурын талбайн зарим резин хавтан алга болсон, зарим хэсэгт хуурсан байна.
- Чингэлтэй дүүргийн 1-р хороонд хийгдсэн 46.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хүүхдийн тоглоомын талбай засварлах ажил”. Цэцгийн мандлын тойруу хэсэгт хийгдсэн суух тавцангууд болон хашлага бетон нь эвдэрсэн.
- Чингэлтэй дүүргийн 8,13-р хороонд хийгдсэн 8-р хороо 134.2 сая төгрөг, 13-р хороо 127.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй хорооны нутаг дэвсгэрт камержуулалд хийх ажлын гүйцэтгэгч “Пропэйшнл солюшн” ХХК. 13-р хороонд 112 ширхэг, 8-р хороонд 124 ширхэг нийт 236 ширхэг камер ашиглалтын шаардлага хангахгүй камер суурилуулснаас 6 сараас хойш ажиллаагүй.
- Чингэлтэй дүүргийн 17-р хороонд хийгдсэн 81.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гудамж сайжруулах ажил”. Явган замын дунд хэсэгт байрлах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч хавтан эвдэрсэн.
- Чингэлтэй дүүргийн 12-р хороонд хийгдсэн 80.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах засварлах ажил”. Сагсны талбайн хашаа эвдэрсэн, талбайн резинэн будаг хагарч хуурсан.

Иймд ОНХС-ийн хөрөнгийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүйгээс эд хөрөнгө эвдрэх, гэмтэх нөхцөл байдал үүсэж байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.



БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНАСАН ЭСЭХ

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны ИТХ, Дотоод аудитын албад хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад нийслэл, БГД, БЗД, БНД, БХД, НД, СХД, ЧД-ийн дотоод аудитаас хяналт хэрэгжүүлсэн бол СБД, ХУД дүүргийн дотоод аудитаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Нийслэл, дүүргийн ИТХ болон холбогдох хороодоос хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дотоод аудит нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналтыг хэрэгжүүлсэн үү?

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 9.4²⁰-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд нийслэл, дүүргийн ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй, дотоод аудитын нэгжээс дараах байдлаар хяналт хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Нийслэлийн дотоод аудитын албанаас НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-үүдийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт;*
- *БГД-ийн дотоод аудитын албанаас ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-үүдийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд аудит хийсэн байна.*
- *БЗД-ийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд аудит хийж “Хангалттай” гэсэн дүгнэлтийг дүүргийн ЗДТГ-т хүргүүлжээ.*
- *БНД-ийн дотоод аудитын албанаас хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлд нийцлийн аудит хийж “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг дүүргийн ЗДТГ-т 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.*
- *БХД-ийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж “Хангалттай” гэсэн дүгнэлтийг дүүргийн ЗДТГ-т хүргүүлжээ.*
- *НД-ийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд аудит хийж “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг дүүргийн ЗДТГ-т хүргүүлжээ.*
- *СХД-ийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналтыг хэрэгжүүлэн 2024 оны 12 сарын 13-ны өдөр СХД-ийн ЗДТГ-т 5 зөвлөмж өгсөн байна.*
- *ЧД-ийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэл, ашиглалт, хамгаалалтад хяналтыг хэрэгжүүлэн 2025 оны 1 сарын 3-ны өдөр ЧД-ийн ЗДТГ-т 7 зөвлөмж өгсөн байна.*
- *СБД, ХУД-ийн дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.*

²⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд ..нийслэл, .. дүүргийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо ...Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, ..нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.”



Тухайн онд нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Нийслэл, дүүргийн дотоод аудитын албадаас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн боловч хяналт шалгалтын үр дүн, тайлан мэдээг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна. Энэ нь СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 9.8²¹ заалттай нийцэхгүй байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ИТХ-аас ОНХС-ийн гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийгдсэн ТАХ-нд захиалагчийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлжээ.

Нийслэл, дүүргийн ОНХС-аар өмнөх оноос дамжин болон шинээр хэрэгжсэн 44,553.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 361 ТАХ-ний гүйцэтгэлд дүүргүүдийн ЗДТГ, НЗХГ, “НХОГ”, СХД-ийн Захиалагчийн алба, “Хан-Уул яармаг” ОНӨААТҮГ, “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ, “Баянзүрх дүүргийн хөгжлийн төв” зэрэг байгууллагууд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 15. Захиалагчийн хяналтын мэдээ

(сая.төг)

№	Нийслэл, дүүргийн нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		Захиалагчийн хяналт				Захиалагчийн хяналтад олгосон дүн
				Хэрэгжүүлсэн ТАХ		Хэрэгжүүлээгүй ТАХ		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Нийслэл	135	15,770.8	135	15,770.8	-	-	172.2
2	БГД	20	1,996.6	20	1,996.6	-	-	-
3	БЗД	36	5,793.1	32	5,196.8	4	596.3	94.6
4	БНД	16	6,123.5	16	6,123.5	-	-	-
5	БХД	5	599.2	3	582.0	2	17.2	14.8
6	НД	39	3,440.9	39	3,440.9	-	-	1.0
7	СБД	7	1,632.1	7	1,632.1	-	-	26.9
8	СХД	68	4,849.9	66	4,824.3	2	25.5	71.1
9	ХУД	7	3,445.1	7	3,445.1	-	-	61.5
10	ЧД	28	902.0	28	902.0	-	-	13.3
НИИТ		361	44,553.1	353	43,914.1	8	639.0	455.4

Аудитын түүвэрт 115 ТАХ-г хамруулан шалгахад захиалагчийн хяналттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.

- БЗД-ийн 41-р хороонд хийгдсэн 151.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажлын гүйцэтгэгч “Чингисийн мэлмий” ХХК. Зогсоолын бродурны хаяавч бетон хийгээгүй, бродур 2 газар рампыг унагааагүй, бродурыг түвшин тааруулаагүй,
- Баянзүрх дүүргийн 40-р хороонд хийгдсэн 388.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй гадна фасад засвар, нэмэлт ажлын гүйцэтгэгч “Нор Вү Инж” ХХК. 17-р байрны хаяавч бетон хийгдээгүй, 71-р байрны усны хаялгын төмөр хийгээгүй.
- БЗД-т хийгдсэн 487.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэгч “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ. Гэрлийн шонгуудыг дугаарлаагүй.
- Баянзүрх дүүргийн 12, 16-р хороонд хийгдсэн 399.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гадна фасад засварын ажил”. Гүйцэтгэгч “Нор Вү Инж” ХХК. Парпед төмрийг бэхлээгүй.

²¹ 9.8.Энэ журмын 9.4, 9.5-д заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ.



- Сонгинохайрхан дүүрэгт хийгдсэн 96.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил” Гүйцэтгэгч “Энх Тэргүүн констракшн” ХХК. Явган замын зарим хэсгийг төмөр хавтангаар хийсэн нь иргэд зорчих аюулгүй байдлыг хангаадаагүй.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний явцад тавих захиалагчийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан уу?

НТАГ-аас “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдвийн хүрээнд нэгдсэн удирдамжийн дагуу аудит хийсэн байна. Дээрх аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-нд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Иргэдийн саналыг эрэмбэлээгүй, үр ашгийн тооцоолол хийгээгүй, шинээр хэрэгжих 9,408.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ нь зураг төсөвгүй баталсан,
- ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 4 ТАХ-д зөрчил илэрсэн,
- Хэрэгжиж дууссан 7,119.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 46 ТАХ-г хөрөнгөд бүртгэж аваагүй,
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгийн талаар УМС-д цаглаварт хугацаанд мэдээлэл оруулаагүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Дээрх илэрсэн зөрчилд нийслэл, дүүргийн Засаг дарга нарт 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийслэл, дүүргүүдийн ИТХ, ЗДТГ болон холбогдох бусад байгууллагуудаас зөвлөмжийн биелэлтийг хугацаа хоцроож ирүүлсэн ч зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

Дүгнэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг дүүргүүд журамд заасан хугацаанаас хоцроож, бүрэн тайлагнаагүй, зарим ТАХ-г нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна. Мөн хэрэгжүүлж буй ТАХ-ний мэдээллийг УМС, шилэн дансны цахим нэгдсэн хуудаст цаг тухай бүр нь үнэн зөв, бүрэн мэдээлэх шаардлагатай байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн тайлагнасан уу?

ОНХС-ийн журмын 9.2²², 9.9²³-д заасны дагуу тайланг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заажээ.

²² Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

²³ 9.9. Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:



Дүүргүүд ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хүргүүлэхдээ журамд заасан зарим мэдээллийг тусгаагүй, хугацаа хоцроосон байна. Тухайлбал:

- Дүүргүүдийн ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нийслэлийн ЗДТГ-т хүргүүлэхэд 25-39 хоногийн хугацаа хоцроож 2025.02.25-аас 03.11-ний хооронд хүргүүлсэн;
- Хүргүүлсэн тайланд олгосон санхүүжилтийг тусгахдаа тухайн жилийн эцсийн байдлаар нэгтгээгүй, аудит болон хяналтын байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмж, албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлагнаагүй, тайлан нь үнэн зөв, иж бүрэн байх шаардлагыг хангаагүй байна.

Дүгнэлт: Дүүргүүд ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг хугацаа хоцроож, журамд заасны дагуу бүрэн тайлагнаагүй, журмын хэрэгжилт хангалтгүй байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?

Тайлант онд хэрэгжиж дууссан 51,239.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 323 ТАХ-ээс 29,101.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 164 ТАХ-г хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн, 16,066.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 106 хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Хөрөнгөд бүртгэх боломжгүй 6,071.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 53 ТАХ-г урсгал зардлаар бүртгэсэн байна.

Хүснэгт 16. ТАХ-г данс бүртгэлд тусгасан байдал

(сая.төг)

№	Нийслэл, дүүргийн нэр	Хөрөнгөнд бүртгэх ТАХ		Бүртгэсэн тах		Шууд зардалд тусгасан		Бүртгээгүй тах	
		ТАХ-ний		ТАХ-ний		ТАХ-ний		ТАХ-ний	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	Нийслэл	123	19,841.5	17	3,775.2			106	16,066.3
2	БГД	18	2,100.1	15	1,063.7	3	1,036.4		
3	БЗД	32	6,649.5	24	4,540.5	8	2,109.0		
4	БНД	15	6,394.0	10	4,355.6	5	2,038.4		
5	БХД	5	855.5	5	855.5				
6	НД	37	3,966.5	26	3,758.9	11	207.6		
7	СБД	7	1,651.1	4	1,355.1	3	296.0		
8	СХД	67	6,320.1	48	6,001.7	19	318.4		
9	ХУД	5	2,612.1	5	2,612.1				
10	ЧД	14	848.7	10	782.8	4	65.9		
	НИИТ	323	51,239.1	164	29,101.2	53	6,071.7	106	16,066.3

Дээрх хүснэгтээс харахад 16,066.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 106 ТАХ-г бүртгээгүй шалтгааныг тодруулахад бичиг баримтын бүрдэл, комиссын акт баталгаажаагүй зэрэг шалтгаантай байна.

Дүгнэлт: Тайлант онд хэрэгжиж дууссан 323 ТАХ-ээс 164 буюу 50.8 хувийг хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;

9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;

9.9.3.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;

9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн фото зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;

9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;

9.9.6.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;

9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга



3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлсэн үү?

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2.1-д²⁴ заасны дагуу тухайн шатны ЗДТГ-ын холбогдох албан тушаалтан нь удирдлагын мэдээллийн системд тухайн онд баталсан ТАХ-ний мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор оруулахаар тусгажээ.

Удирдлагын мэдээллийн <https://onhs.mof.gov.mn/> системд байршуулсан мэдээллийг шалгахад 2024 онд хэрэгжих 529 ТАХ-ээс 40 ТАХ-ний буюу 7.6 хувийн мэдээллийг оруулсан байна.

Хүснэгт 17. Удирдлага мэдээллийн системд байршуулсан байдал

№	Нэр	УМС-д оруулах ТАХ-ний тоо			УМС-д оруулсан байгаа тоо
		2024 оны ТАХ	Он дамжсан ТАХ	Нийт	
1	Нийслэл	143	97	240	0
2	БГД	13	10	23	23
3	БЗД	20	29	49	0
4	БНД	18	4	22	17
5	БХД	5	1	6	0
6	НД	44	4	48	0
7	СХД	5	4	9	0
8	СБД	72	9	81	0
9	ХУД	5	8	13	0
10	ЧД	25	13	38	0
	Нийт	350	179	529	40

(2025 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар)

Хүснэгтээс харахад нийсэл болон БЗД, БХД, НД, СХД, СБД, ХУД, ЧД-үүд нь удирдлагын мэдээллийн системд н мэдээлэл байршуулаагүй, БГД 100 хувь, БНД нь 77 хувьтай байршуулсан байна.

Мэдээллийг байршуулаагүй нь холбогдох албан хаагчдын хариуцлагагүй байдал, шат шатны хяналт хангалтгүйтэй холбоотой.

Дүгнэлт: Нийслэл, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг удирдлага мэдээллийн системд оруулаагүй, дутуу байршуулсан зэргээр журмын хэрэгжилт хангалтгүй байна.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь мэдээлсэн үү?

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1²⁵, 6.1.2²⁶, 6.3.9²⁷ -т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор мэдээлэхээр заасан.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

Хүснэгт 18. Шилэн дансны мэдээлэл

№	Нэр	ОНХС-ийн төлөвлөгөө	ОНХС-ийн гүйцэтгэл												Нийт
			1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	
1	Нийслэл	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	13
2	БГД														
3	БЗД					1									1

²⁴ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна

²⁵ 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

²⁶ 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

²⁷ 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.



4	БНД														
5	БХД		1		1			1		1					4
6	НД														
7	СБД														
8	СХД														
9	ХУД	1									1				2
10	ЧД										1				1
	Нийт	2	2	1	2	1	2	2	1	2	3	1	1		1

Тайлбар: 1-Хугацаа хоцроосон болон дутуу оруулсан

Хүснэгтээс харахад БНД, СБД, БГД, СХД, НД-ийн ЗДТГ ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь мэдээлсэн байна.

Харин нийслэл, БЗД, БХД, ХУД, ЧД-ийн ЗДТГ шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мэдээлэл нь бүрэн бус байна.

Цаашид дээрх дүүргүүд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд бүрэн гүйцэд байршуулж хэвших шаардлагатай байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллээ бүрэн оруулаагүй байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдийн саналд үндэслэн орон нутгийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн төлөвлөсөн байна.
2. Нэр байршил тодорхой бус, зураг төсөвгүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй зарим ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна.
3. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан ч шаардлага хангаагүй зарим гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.
4. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс хөрөнгө эвдэрч гэмтсэн байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэлд ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.
6. ОНХС-ийн хэрэгжилтийн тайлан мэдээг удирдлага мэдээллийн систем болон шилэн дансны цахим хуудсанд дутуу байршуулж, хугацаа хоцроож мэдээлсэн байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт:

1. Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангасан ТАХ-г төлөвлөж батлуулах;
2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлэн, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;
3. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, эзэнжүүлэх талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах;
4. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;
5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах;
6. Төсөл арга хэмжээний мэдээллийг удирдлага мэдээллийн систем болон шилэн дансанд цаг тухайд нь бүрэн гүйцэд байршуулж байх.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Замчдын гудамж 3, 27 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16052
Утас: (976) 7012 0320
Цахим шуудан: info@bgd.mn
Цахим хуудас: www.bgd.mn

2025.09.23 № 02/2427
танай 2025.09.17 -ны № 708 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.

Хавсралт 1 хуудастай.



Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
Тамгын газрын дарга
Тамгын газрын дарга
Батболд МӨНГӨНХУЯГ
2025.09.23 16:59



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Энхтайваны өргөн чөлөө-57, 13 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас/Факс: (976-51) 26 63 59
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2025.09.23 № 02/2274
танай -ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Тус дүүрэгт хэрэгжүүлсэн "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/31-11-ШТА-ГА) тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.

Цаашид тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Дамдинбат Цэнд-Очир
2025.09.23 14:58



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.Нацагдоржийн талбай, Наран хороолол,
1 дүгээр хороо, Багануур дүүрэг,
Улаанбаатар хот, 12090
Утас/Факс: (976) 7021 0017, 7021 0330
Цахим шуудан: info@bnd.ub.gov.mn
Цахим хаяг: www.bnd.ub.gov.mn

2025.09.23 № 01/1025
танай 2025.09.17 -ны № 708 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Гарсан зөрчлийг цаашид гаргахгүй байхад анхааран ажиллах болно.



Багануур дүүргийн засаг даргын тамгын газар
Захиргаа
Багануур дүүргийн засаг дарга
Сумъяа Даваасүрэн
2025.09.23 16:21

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Өндөр толгой, 1 дүгээр хороо,
Багахангай дүүрэг, Улаанбаатар хот, 12330
Утас: (976) 7049 1011
Цахим хуудас: www.bagakhangai.ub.gov.mn

2025.09.23 № 04/660
танай 2025.09.17 -ны № 708 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2025/31-11-ШТАГА/ тайлангийн зөвлөмж, дүгнэлтэд саналгүй болно.

Хавсралт 1 хуудастай.



Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар
Удирдлага
Тамгын дарга
Лхагваа Санжийжамц
2025.09.24 08:59



**НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Д.Даваажавын гудамж,
2 дугаар хороо, Налайх дүүрэг,
Улаанбаатар хот 12790
Утас: (976) 7023 2252, 7023 2204
Цахим шуудан: nalaikh@webmail.com
Цахим хуудас: www.nad.ub.gov.mn

2025.09.22	№	01/1893
танай	2025.09.17	-ны № 708 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.



Налайх дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг дарга
Дашзэвэг Наянбаяр
2025.09.22 15:13



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 2216
Цахим хуудас: www.shd.mn

2025.09.23	№	01/3257
танай	2025.09.17	-ны № 708 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Нийслэлийн төрийн аудитаар "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар шалгагдсан. Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд аудитын тайлангийн төсөлд өгөх саналаа 10 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн манай байгууллагын зүгээс өгөх "Саналгүй" болно.



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг дарга
Цэдэндамба Баттөр
2025.09.23 14:09



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Иргэдэд үйлчлэх төв байр,
Чингисийн өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас: (976) 7777 1965
Цахим шуудан: info@khanuul.mn
Цахим хуудас: www.khanuul.mn

2025.09.22	№	04/1400
танай		-ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийгдсэн гүйцэтгэлийн тайлантай танилцсан.

Тайлангийн үр дүнтэй санал нийлж хүлээн зөвшөөрч байна. Цаашид алдаа зөрчлийг дахин гаргуулахгүй байхад анхааран ажиллах болно.



Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Заяабаатар Буянт
2025.09.23 13:49



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж 16, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7777 1992
Цахим шуудан: info@chingeltai.gov.mn
Цахим хуудас: www.chingeltai.gov.mn

2025.09.23	№	03/2737
танай		-ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2025/31-11-ШТА-ГА/ тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу саналгүй болно.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын дарга
Жаргал Тамир
2025.09.23 16:19



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Денверийн гудамж 13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190, Утас: (976) 7007 0109
Цахим шуудан: info@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2025.09.24 № 01/2507
танай 2025.09.17 -ны № 708 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах болно.



Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг дарга
Мөнхмагнай Алтангэрэл
2025.09.24 12:13



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Навдамдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.09.25 № 03/6077
танай _____ -ны № _____ -т

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА**

Танай газраас ирүүлсэн 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 01/708 дугаартай албан бичигтэй танилцлаа.

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2025/31-11-ШТА-ГА/ тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АМГАЛАН

1725114746



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Нийслэл, дүүргийн ЗД болон ЗДТГ-аас аудитын тайлангийн төсөлтэй танилцаж Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд саналаа ирүүлж, цаашид аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллахаа илэрхийлсэн.

**ХАВСРАЛТ****Хавсралт 1. НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх ерөнхий нэршлээр баталсан ТАХ-ний жагсаалт**

№	Нэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг (сая.төг)
1	БГД	Ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн ерөөний тохижилт, засварын ажил (БГД)	2024	2024	400.0
2	БГД	Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж (БГД)	2024	2024	400.0
3	БГД	Сургууль, цэцэрлэгийн камержуулалт, дагалдах тоног төхөөрөмж (БГД)	2024	2024	400.0
4	БГД	Бүтээн байгуулалт, тохижилтын ажил (БГД)	2024	2024	400.0
5	БЗД	Амьдрах орчин сайжруулах (БЗД, 2 дугаар хороо)	2024	2024	200.0
6	БЗД	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (БЗД, 11 дүгээр хороо)	2024	2024	400.0
7	БЗД	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт (БЗД)	2024	2024	30.0
8	СХД	Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын ажил (СХД)	2024	2024	400.0
9	СХД	Спорт талбай тохижуулах ажил (СХД)	2024	2024	400.0
10	СХД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	2024	2024	400.0
11	СХД	Сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж (СХД)	2024	2024	400.0
12	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	2024	2024	400.0
13	СХД	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (СХД)	2024	2024	551.0
14	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	2024	2024	400.0
15	СХД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт, камержуулалт (СХД)	2024	2024	400.0
16	СХД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	2024	2024	479.0
17	СХД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	2024	2024	400.0
18	СБД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засвар шинэчлэлт (СБД)	2024	2024	400.0
19	СБД	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (СБД)	2024	2024	400.0
20	ХУД	Шүдний кабинет байгуулах (ХУД)	2024	2024	150.0
21	ХУД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (ХУД)	2024	2024	400.0
22	ХУД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж (ХУД)	2024	2024	400.0
23	ХУД	Боловсролын байгууллагуудын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн (ХУД)	2024	2024	400.0
24	ЧД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил (ЧД)	2024	2024	800.0
25	ЧД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (ЧД)	2024	2024	400.0
26	БХД	Тохижилт, ногоон байгууламжийн ажил (БХД, 1, 2 дугаар хороо)	2024	2024	80.0
27	НД	Тохижилтын ажилд шаардлагатай материал худалдан авах (НД)	2024	2024	400.0
28	Нийслэл	БУСАД	2024	2025	12,696.6
Нийт					22,986.6

Хавсралт 2. ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх ерөнхий нэршлээр баталсан ТАХ-ний жагсаалт

№	Дүүрэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг (сая.төг)
1	БГД	Дээвэр засвар	2024	2024	255.0
2	БГД	Явган зам, засварын ажил	2024	2024	130.0
3	БГД	Өнгөлгөөний фасад 17-р хороо	2024	2024	100.0
4	БГД	Цахилгаан шат засварын ажил (1 дүгээр хороо)	2024	2024	20.0
5	БГД	Тоглоомын талбайн тоног төхөөрөмж	2024	2024	80.0
6	БГД	Нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр засварын ажил	2024	2024	729.2
7	БЗД	Авто зам засварын ажил (БЗД, 1 дүгээр хороо)	2024	2024	151.4
8	БЗД	Тохижилтын ажил (БЗД 4 дүгээр хороо)	2024	2024	370.1
9	БЗД	Дээвэр засварын ажил (БЗД, 7 дугаар хороо)	2024	2024	497.5
10	БЗД	Авто зам засварын ажил БЗД 5,7 дугаар хороо)	2024	2024	423.3
11	БЗД	Тохижилтын ажил (БЗД, 11 дүгээр хороо)	2024	2024	372.4
12	БЗД	Гадна фасад засварын (БЗД 12, 16 дугаар хороо)	2024	2024	399.2
13	БЗД	Дээвэр засварын ажил (БЗД, 13, 40 дүгээр хороо)	2024	2024	327.1
14	БЗД	Тохижилтын ажил (БЗД, 14 дүгээр хороо)	2024	2024	117.1
15	БЗД	Дээвэр засварын ажил БЗД, 25 дугаар хороо)	2024	2024	135.9
16	БЗД	Тохижилтын ажил (БЗД, 32 дугаар хороо)	2024	2024	138.1
17	БЗД	Тохижилтын ажил (БЗД, 34 дүгээр хороо)	2024	2024	341.2
18	БЗД	Явган замын ажил (БЗД, 37 дугаар хороо)	2024	2024	167.0
19	БЗД	Дугуйн болон явган замын ажил (БЗД, 39 дүгээр хороо)	2024	2024	153.1



Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

20	БЗД	Гадна фасад засвар, нэмэлт ажил (БЗД, 40 дүгээр хороо)	2024	2024	675.6
21	БЗД	Тохижилтын ажил (БЗД, 41 дүгээр хороо)	2024	2024	151.2
22	БЗД	Авто болон явган зам засварын ажил (БЗД, 42 дугаар хороо)	2024	2024	96.3
23	БЗД	Тохижилтын ажил (БЗД, 43 дугаар хороо)	2024	2024	307.4
24	БЗД	Дэд бүтцийн ажил (БЗД.)	2024	2024	303.3
25	СБД	Тохижилт бүтээн байгуулалт хийх	2024	2024	66.4
26	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	120.3
27	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	100.0
28	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	89.0
29	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх	2024	2024	122.8
30	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	100.0
31	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	100.0
32	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	64.5
33	СХД	Гэрэлтүүлэг/12 ш/	2024	2024	27.6
34	СХД	Явган хүний зам шинээр хийх	2024	2024	100.0
35	СХД	Автомашинь зогсоол байгуулах	2024	2024	144.7
36	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	16.3
37	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх	2024	2024	72.0
38	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх	2024	2024	91.7
39	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	100.5
40	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	80.0
41	СХД	Явган хүний зам шинээр хийх	2024	2024	60.0
42	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	59.1
43	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	60.0
44	СХД	Автомашинь зогсоол байгуулах	2024	2024	80.0
45	СХД	Автомашинь зогсоол байгуулах	2024	2024	99.9
46	СХД	Автобусны буудлын тохижилт	2024	2024	100.0
47	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх	2024	2024	87.6
48	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх	2024	2024	97.5
49	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	48.6
50	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	50.0
51	СХД	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг сайжруулах	2024	2024	70.0
52	СХД	Явган хүний зам шинээр хийх	2024	2024	100.0
53	СХД	Автомашинь зогсоол байгуулах	2024	2024	100.0
54	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	133.3
55	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил 2-р хороо	2024	2024	100.0
56	СХД	Явган хүний зам шинээр хийх	2024	2024	100.0
57	СХД	Гэрэлтүүлэг	2024	2024	147.3
58	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил 37-р хороо	2024	2024	100.0
59	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	140.7
60	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	80.0
61	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх	2024	2024	106.9
62	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	2024	2024	100.0
63	СХД	Явган замын нэмэлт ажил	2024	2024	11.3
64	СХД	Зураг, төсөв боловсруулах зардал	2024	2024	996.9
65	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах	2024	2024	49.0
66	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах	2024	2024	43.8
67	ЧД	Нийтийн зориулалттай талбайд ногоон байгууламж хийх (авто зогсоол)	2024	2024	78.8
68	ЧД	Камержуулалт болон арчлалт хамгаалалт	2024	2024	161.1
69	ЧД	Нийтийн зориулалттай талбайд ногоон байгууламж хийх (авто зогсоол)	2024	2024	59.6
70	ЧД	Авто машины зогсоол	2024	2024	42.2
71	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах	2024	2024	77.0
72	ЧД	Камержуулалт	2024	2024	85.1
73	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	47.1
74	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	80.4
75	ЧД	Камержуулалт	2024	2024	91.1
76	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	62.6



77	ЧД	Хүүхдийн тоглоомын талбайг байгуулах, засварлах	2024	2024	86.7
78	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	89.9
79	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	83.2
80	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	109.8
81	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	100.6
82	ЧД	Камержуулалт	2024	2024	101.8
83	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	101.3
84	ЧД	Камержуулалт	2024	2024	96.0
85	ЧД	Ногоон байгууламж	2024	2024	67.3
86	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	90.5
87	ЧД	Гудамж сайжруулах	2024	2024	51.8
88	ЧД	Камержуулалт	2024	2024	58.1
89	ЧД	Камержуулалт	2024	2024	35.8
Нийт					12,816.6

Хавсралт 3. НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт

№	Дүүрэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Шинэ шилжих	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг (сая.төг)
1	БГД	58 дугаар байрны 3-р орчны дээвэр засварын ажил (БГД, 19 дүгээр хороо)	Их засвар	Шинэ	2024	40.0
2	БГД	Бичил хороолол, УДДТ-98-н харьяа 56 дугаар байрны 1-р орчноос 16 дугаар байр хүртэлх халаалтын ф80 мм, хэрэглээний халуун усны ф/80/50 мм, хүйтэн усны ф80 мм 5 хос шугам шинэчлэн солих ажил (БГД)	Дэд бүтэц	Шинэ	2024	187.1
3	БЗД	Амьдрах орчин сайжруулах (БЗД, 2 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	2024	200.0
4	БЗД	Хүүхэд хамгаалах түр байрыг цахилгаанаар хангах 250кВт-ын бүрэн автомат цахилгаан үүсгүүрийг худалдан авч суурилуулах ажил (БЗД)	Дэд бүтэц	Шинэ	2024	100.0
5	БЗД	Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Д" хэсэгчилсэн талбайн өндөр хүчдэлийн шугам сүлжээг зөөх ажил (БЗД, 13, 14 дүгээр хороо)	Дэд бүтэц	Шинэ	2024	150.0
6	БЗД	Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Д" хэсэгчилсэн талбайн инженер шугам сүлжээний ажил (БЗД, 13, 14 дүгээр хороо)	Дэд бүтэц	Шинэ	2024	150.0
7	БЗД	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт (БЗД)	Тохижилт	Шинэ	2024	30.0
8	БЗД	Хаппи таун хотхон 69 дүгээр сургуулийн дунд зам талбайн тохижилт (БЗД, 5 дугаар хороо)	Авто зам	Шинэ	2024	70.0
9	СХД	Спорт талбай тохижуулах ажил (СХД)	Тохижилт	Шинэ	2024	400.0
10	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	Тохижилт	Шинэ	2024	400.0
11	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	Тохижилт	Шинэ	2024	400.0
12	СХД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	Тохижилт	Шинэ	2024	479.0
13	СБД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засвар шинэчлэлт (СБД)	Тохижилт	Шинэ	2024	400.0
14	СБД	Гэр хороолол дундах зам түрж тэгшлэх ажил (СБД, 15, 16, 18 дугаар хороо)	Авто зам	Шинэ	2024	400.0
15	ХУД	Шүдний кабинет байгуулах (ХУД)	Тохижилт	Шинэ	2024	150.0
16	ХУД	Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Нийслэлийн ерөнхий боловсролын 34, 41 дүгээр сургуулийн засварын ажил (ХУД)	Их засвар	Шинэ	2024	110.0
17	ХУД	"Уясах" өрхийн эрүүл мэндийн төвийн Үйлчилгээний хүлээлгийн хэсэг буюу хөтөч сувилагчийн постын тохижилт (ХУД)	Тохижилт	Шинэ	2024	19.0
18	ЧД	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил (ЧД)	Тохижилт	Шинэ	2024	800.0
19	ЧД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (ЧД)	Тохижилт	Шинэ	2024	400.0
20	НД	Жишиг амралт, чөлөөт цаг өнгөрөөх тоглоомын талбай байгуулах (НД 1 дүгээр хороо)	Тохижилт	Шинэ	2024	150.0
21	ЧД	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын засвар (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	Их засвар	Шинэ	2024	1,996.4
22	СХД	Төмөр зам доогуурх авто машины нүхэн гарцын ажил (СХД, 32 дугаар хороо)	Авто зам	Шинэ	2024	777.7
23	СХД	Явган гүүрний ажил (30 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	2024	
24	СХД	Явган гүүрний ажил (43 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	2024	
25	СХД	119 дүгээр анги орчмын гадаргын ус зайлуулах шугамын ажил	Дэд бүтэц	Шинэ	2024	592.5
26	БЗД	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны засвар (БЗД, 3 дугаар хороо)	Их засвар	Шинэ	2024	150.0



27	СХД	Явган гүүрний ажил (30 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	2024	57.5
28	СХД	Явган гүүрний ажил (43 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	2024	
29	СХД	119 дүгээр анги орчмын гадаргын ус зайлуулах шугамын ажил	Дэд бүтэц	Шинэ	2024	
30	СБД	Хүрээ амаржих газрын дулааны шугамын засвар (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	Их засвар	Шинэ	2024	54.2
31	БЗД	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт (БЗД, 11 дүгээр хороо)	Тохижилт	Шинэ	2024	50.0
Нийт						8,713.4

Хавсралт 4. ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт

Д/д	Дүүрэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Шинэ шилжих	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг (сая.төг)
1	БГД	Замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах ажил (11, 26 дугаар хороо)	их засвар, тохижилт	Шинэ	2024	15.0
2	БГД	Цахилгаан шат засварын ажил (1 дүгээр хороо)	их засвар, тохижилт	Шинэ	2024	20.0
3	БГД	Бохирын шугам солих ажил (2 дугаар хороо)	их засвар, тохижилт	Шинэ	2024	20.0
4	БГД	Тоглоомын талбайн тоног төхөөрөмж	их засвар, тохижилт	Шинэ	2024	80.0
5	БГД	Найрамдал цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажил	их засвар, тохижилт	Шинэ	2024	19.2
6	БГД	Гэрэлтүүлгийн ажил (9, 21 дүгээр хороо)	их засвар, тохижилт	Шинэ	2024	20.0
7	БГД	Гэрэлтүүлгийн ажил (10, 22, 29 дүгээр хороо)	их засвар, тохижилт	Шинэ	2024	18.9
8	БГД	Гэрэлтүүлгийн ажил (Ард Аюушийн өргөн чөлөө, 25, 27 дугаар хороо)	их засвар, тохижилт	Шинэ	2024	18.0
9	БХД	Багахангай дүүргийн нэгдүгээр хорооны 2, 3, 4, 5, 6 дугаар байр, хоёрдугаар хорооны 5, 6, 7, 9, 12, 13, 14 дугаар байрны орон сууцуудын фасадын өнгө сэргээх засварын ажил	Их засвар	Шинэ	2024	549.4
10	БХД	Багахангай дүүргийн хоёрдугаар хорооны “Улаан худгийг засварлах” ажил	Их засвар	Шинэ	2024	15.0
11	БХД	Багахангай дүүргийн хоёрдугаар хорооны “Хадатын худгийг засаж хашаажуулах” ажил	Их засвар	Шинэ	2024	5.3
12	БХД	2 дугаар хорооны Соёлын төвийн засварын ажил	Их засвар	Шинэ	2024	15.6
13	НД	5 дугаар хороо автобусны буудал	Тохижилт	Шинэ	2024	20.0
14	НД	Сурьн талбайн тохижилт	Их засвар	Шинэ	2024	19.2
15	НД	31 А, Б байрны дээвэр засвар	Их засвар	Шинэ	2024	19.4
16	НД	Замчин хэсгийн гүүр засварлах	Их засвар	Шинэ	2024	20.0
17	СБД	20-р хороо, Цуурайтын аманд тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгах хайрга, дайрган хучилт хийх	Тохижилт	Шинэ	2024	245.0
18	СБД	Тохижилт бүтээн байгуулалт хийх	Тохижилт	Шинэ	2024	66.4
19	СХД	Гэрэлтүүлэг /1-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	120.3
20	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /2-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.0
21	СХД	Гэрэлтүүлэг /3-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	89.0
22	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх /4-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	122.8
23	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /5-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.0
24	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /6-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.0
25	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /7-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	64.5
26	СХД	Гэрэлтүүлэг /12 ш/ /7-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	27.6
27	СХД	Гэрэлтүүлэг /13-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	16.3
28	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх /13-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	72.0
29	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх /14-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	91.7
30	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /15-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.5
31	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /16-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	80.0
32	СХД	Гэрэлтүүлэг /18 дугаар хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	59.1
33	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /18 дугаар хороо/	Тохижилт	Шинэ	2024	60.0
34	СХД	Автобусны буудлын тохижилт /21-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.0
35	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх /22-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	87.6



Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

36	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх /23-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	97.5
37	СХД	Гэрэлтүүлэг /24-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	48.6
38	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /24-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	50.0
39	СХД	Гэрэлтүүлэг /25-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	93.9
40	СХД	Гэрэлтүүлэг /26-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	110.9
41	СХД	Гэрэлтүүлэг /27-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	114.0
42	СХД	Гэрэлтүүлэг /32-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	130.4
43	СХД	Гэрэлтүүлэг /33-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	133.3
44	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /34-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	100.0
45	СХД	Гэрэлтүүлэг /36-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	147.3
46	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /37-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.0
47	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /38-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	140.7
48	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /40-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	80.0
49	СХД	Гэрэлтүүлэг /41-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	134.6
50	СХД	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх /42-р хороо/	Гэрэлтүүлэг	Шинэ	2024	106.9
51	СХД	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /43-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	100.0
52	ХУД	Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил (3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 13, 14, 16, 19, 23, 24 дүгээр хороо)	Дэд бүтэц	Шинэ	2024	1,833.9
53	ХУД	Тохижилт бүтээн байгуулалтын ажил (1, 2, 7, 18, 19, 22, 25 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	2024	800.0
54	ХУД	3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажил (15, 20, 24 дүгээр хороо)	Барилга байгууламж	Шинэ	2024	250.0
55	ХУД	Автобусны буудлын засвар тохижилтын ажил (9, 10, 14, 21 дүгээр хороо)	Тохижилт	Шинэ	2024	540.7
56	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах /1-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	49.0
57	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах /2-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	43.8
58	ЧД	Нийтийн зориулалттай талбайд ногоон байгууламж, хийх (авто зогсоол) /3-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	78.8
59	ЧД	Нийтийн зориулалттай талбайд ногоон байгууламж, хийх (авто зогсоол) /5-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	59.6
60	ЧД	Авто машины зогсоол 6-р хороо	Авто зам	Шинэ	2024	42.2
61	ЧД	Хүүхдийн тоглоомын талбай засварлах 6-р хороо	Тохижилт	Шинэ	2024	77.0
62	ЧД	Гудамж сайжруулах /8-р хороо/	Авто зам	Шинэ	2024	47.1
63	ЧД	Гудамж сайжруулах /9-р хороо/	Авто зам	Шинэ	2024	80.4
64	ЧД	Гудамж сайжруулах /11-р хороо/	Авто зам	Шинэ	2024	62.6
65	ЧД	Хүүхдийн тоглоомын талбайг байгуулах, засварлах /12-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	86.7
66	ЧД	Гудамж сайжруулах /13-р хороо/	Авто зам	Шинэ	2024	89.9
67	ЧД	Гудамж сайжруулах /14-р хороо/	Авто зам	Шинэ	2024	83.2
68	ЧД	Гудамж сайжруулах /15-р хороо/	Авто зам	Шинэ	2024	109.8
69	ЧД	Гудамж сайжруулах /16-р хороо/	Авто зам	Шинэ	2024	100.6
70	ЧД	Гудамж сайжруулах /18-р хороо/	Авто зам	Шинэ	2024	101.3
71	ЧД	Ногоон байгууламж /20-р хороо/	Тохижилт	Шинэ	2024	67.3
72	ЧД	Гудамж сайжруулах /21-р хороо/	Авто зам	Шинэ	2024	90.5
73	ЧД	Гудамж сайжруулах /22-р хороо/	Авто зам	Шинэ	2024	51.8
Нийт						9,011.7